



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Даваа гараг

| | |
|--|------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга | 1 |
| Хуралдааны товч тэмдэглэл: | 2-5 |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 6-20 |

| | |
|---|-------|
| 3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 6-13 |
| 3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 13-19 |
| 3.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг | 19-20 |

/

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит
чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны
12 дугаар сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 33 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ;
Чөлөөтэй: Б.Баярбаатар, Б.Батбаатар, Л.Мөнхбаатар,
Н.Номтойбаяр, Э.Одбаяр, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Солонгоо, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батхуяг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын

хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, мэргэжилтэн П.Энхманлай, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүү, төсвийн судалгааны газрын ахлах шинжээч З.Анар, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт А.Наранцэцэг, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Х.Зулпхарын гаргасан, “Ургамал хамгааллын газар” гэсний дараа “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газар Хэрэгжүүлэгч агентлаг хэсэгт “Төмөр замын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 10
Бүгд: 13
23.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ оройн мэндийг хүргэе ээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн Жудгийн Баярмаа, Сархадын Зулпхар Цэвэгдоржийн Туваан, Өлзийхүүгийн Шижир, Дашзэвэгийн Амарбаясгалан, Энхбатын Болормаа, Одсүрэнгийн Номинчимэг, Ням-Осорын Учрал, Сайнбуянгийн Амарсайхан, Лувсаннъямын Гантөмөр, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг нарын гишүүд хүрэлцэн ирснээр ТББХ-ны 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэнэ.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Засгийн газар 2024 оны 12 сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2 дахь хэлэлцэх асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд, Засгийн газар 2024 оны 12 сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

3 дахь хэлэлцэх асуудал. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2024 оны 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

Ийм 3 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Байхгүй юу? Хэлэлцэх асуудал батлагдлаа.

Хэлэлцэх асуудалдаа орёе, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье ээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Ороод суугаад байгаарай. Гялс гялс орчих ажлын хэсгийнхэн. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Б.Баасандорж Улсын Их Хурлын ЕНБД. Баасандорж дарга

хаачсан дуудаарай. Д.Дэлгэрнаран СЕХ-ны дарга, Д.Баянбилиг ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Б.Солонгоо Засгийн газар Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Б.Пүрэвдагва Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Д.Ариунболд ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга байна уу? Ариунболд дарга. Б.Мөнх-Оргил Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Онцгой байдлын асуудал хариуцсан. Мөнх-Оргил байна уу? Н.Лхагвадорж Хяналт үнэлгээний үндэсний хорооны Нарийн бичгийн дарга байна, З.Лхагвадорж Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Өрсөлдөөний асуудал хариуцсан. Байна уу? Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Загджав дарга өөрөө байгаа юм байна, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Сангийн яамныхан орж ирээгүй байна уу? Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Д.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга. Эдийн засгийн байнгын хорооноос орж ирэх юм байна. Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Б.Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, С.Баярбаатар Монгол Улсын сайд 20 минутын хот, Үндэсний хорооны бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч.

Эдгээр ажлын хэсгийн гишүүд. Сангийн яамныхан орж ирж байна уу? Ажлын хэсгийн гишүүд байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулж дууслаа.

Сангийн сайд ирж байна уу? Ирж байна уу Ганбат дарга? Наашаа гарсан уу айн? Байнгын хороод 1-ээс 2 цагийн зайтай хуралдаж байгаа учраас тэгээд Сангийн яам, Сангийн сайд, Сангийн яамныхан бүгд хуралдаанууд дээр байж байгаа учраас бас хурлууд давхцаад бас жоохон хугацаа хоцорч явж байгааг зөв ойлгоорой.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан орж ирж танилцуулна аа.

Ингэж л байна л даа. Дэгийн тухай хуулийн 71.71.2 дээр төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг 71.2 санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон Дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна гэсэн байна 71.2.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүдээс уучлалт хүсье ээ. Өнөөдөр чинь 10 гаран Байнгын хороод дараалаад явж байгаа учраас Дараагийн Байнгын хороодыг бас хүлээлгээд байх шиг байна. Уучлаарай.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьж байна. Төсвийн төсөлд зардлыг бууруулах дараах зарчмыг баримталлаа.

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж ЭМД-ын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж гэх мэт яг өрхийн орлогод шууд нөлөөлдөг төсвийн зардлуудыг хэвээр нь өргөн барьж байна. Мөн үүн дээр гадаад зээлийн үйлчилгээний төлбөр мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-оос төсвийг нь хянаж жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн байгууллагууд ХЭҮК зэрэг байгууллагуудын урсгал зардлуудыг тус тус бууруулсангүй.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь бууруулна. Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулъя.

Б.Соёлын Эрхийн бичиг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих Кино урлагийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна.

В.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, ХЗДХ-ийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл, худалдан авах зардлыг тус бүр 50 хувиар бууруулъя. Дээр дурдсан 50-аас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт, эм бэлдмэл,

нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто замын гүүрэн байгууламжийн засвар ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгая аа.

Харин гэрээ байгуулаагүй ажил эхлээгүй Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна аа. Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж хэлэлцээрийн шатад байгаа төслүүдийг хойшлуулна.

6.Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж бууруулахаас өөр аргагүй болж байна. Хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон зарим төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулна.

7.ХӨСҮТ. 2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа. Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт зарлагын бууралттай холбогдуулан 394.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувь нийт зардал байгаагаас ер зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувьд хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж суурь тэнцэл ДНБ-ий 3.3 хувийн ашигтай болохоор байна аа.

Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 улсын төсөл, орон тогтоолын төслийг боловсрууллаа.

Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Танилцуулга хийсэн Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 3 дугаар номерын микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ үдшийн мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын ТББХ-ны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн, аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025-ны оны төсвийг үр ашигтай хэмнэлттэй алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна аа.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээн авч алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьжээ.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгод нийцэж байгаа эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн. Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус байнгын хороонд хамаарах.

Ц.Сандаг-Очир: 3 номерын микрофон.

Д.Загджав: Тус байнгын хороонд хамаарах төсвийн 9 ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогыг 2025 онд 107.2 тэрбум, зарлагыг 1 их наяд 68.3 тэрбум төгрөг байхаар тус тус төлөвлөжээ. Үүнд ҮХЦ-ийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын дарга, Монгол улсын ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, СЕХ-ны дарга, ТАЗ-ийн дарга, Монгол Улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга.

Монгол Улсын 2025 оны зэвсгийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй.

1.Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна аа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөлд өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ачааллыг бууруулж байна.

3.Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ,

заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэйд тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зарлагыг хумьж зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүн нийцлийн харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5.Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна аа.

6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно оо.

Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурал, Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль түүнд нийцүүлэн гарсан зарим нэг хууль тогтоомжтой нийцэхгүй байгааг бас анхаарах шаардлагатай байна аа.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Загджав даргад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг гишүүд та бүхэнд хүргүүлсэн.

Одоо хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд байна уу? Зулпхар гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Хуралдаан даргалагч Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн оройн амар амгаланг айлтгая. Нэг тодруулах л зүйл байгаа юм энэ шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн хяналтын гол үндсэн институт болсон ҮХЦ-ийн бас төсөвтэй холбоотой зүгээр тодруулга хийнэ. Харьцангуй одоо жишээ нь цомхон бүтэцтэй ийм байгууллага. Гэхдээ шүүх ҮХЦ-ийн хувьд бол Үндсэн хуулийн хяналтын гол институт учраас үйл ажиллагаа нь бол ер нь аль ч үед их чухал байдаг л даа.

Тэгэхээр яах вэ энэ бид шүүх эрх мэдлийн байгууллагуудын төсвийг аль болох хүрэхгүй байхаар бас ер нь аль аль түвшинд ер нь ярилцаж байсан. Ер нь

шүүх эрх мэдэл өөрөө бие даасан эрх мэдэл учраас төсөв мөнгөний асуудалд ер нь аль болох гар хүрэхгүй шүү гэсэн. Шүүхийн ерөнхий зөвлөл дээр ч гэсэн энэ зүйлийг ер нь барьсан юм шиг байна. ҮХЦ дээрээс нэг 5 зуугаад сая төгрөг 577 сая төгрөг хасчихсан л байна л даа. Яах вэ 10 хувиар нь юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ хэвийн үйл ажиллагаа явуулахад нь хэр нөлөөлөх вэ яадаг бол гэсэн ийм л асуулт тодруулга л байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Асуултад хэн хариулах вэ? Жавхлан сайд уу? 4 номерын микрофон.

Б.Жавхлан: Зулпхар гишүүний асуултад хариулья аа.

Яах вэ өнөөдөр ингээд 11 дэх Байнгын хороо. Байнгын хороо болон өөр өөрсдийнхөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвөөс танагдах ёсгүй гээд ерөнхийдөө хамгаалах чиглэлд л байх юм. Зүгээр энд 2 талтай л даа. Нэгэнт хэрвээ бид нар том шийдвэр гаргаад төсвийн алдагдалгүй байя гэдэг ийм том бодлогын формат руу шилжиж байгаа тохиолдолд уг нь энэ өмнөх шийдвэрээ дагаад энийгээ дэмжээд явчихвал их ойлгомжтой байх юм. Тэгэхгүй ингээд дахиад буцаад ойлгомжгүй байдал үүсгээд буцаагаад зардал хассан нь бараг буруу байсан. Анх оруулж ирсэн төсөв нь бараг зөв байсан гээд ингээд нэг эргэж буцсан байдалтай л бүгд Байнгын хороон дээр л явлаа л даа. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн хувьд бол яг урсгал зардал дээрээсээ бусад төсвийн хэрэглэгч нартайгаа яг ижилхэн зарчмаар л 10 хувь хасагдсан байгаа.

Тэгэхээр яах вэ сүүлийн жилүүдэд ДНБ-ий энэ өсөж байгаа тэлж байгаа боломж төсвийн энэ мөн хөгжлөө дэмжиж тэлж байгаа энэ суурь зардлууд дотор бас өсөөд л явсан. Тэгэхээр 10 хувь хасагдлаа гээд үйл ажиллагааны доголдол үүсээд ийм эрсдэл гарахгүй болов уу гэж ингэж бодож байна. Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүх байгууллагуудын хувьд бол ХЗБХ-н дээр төсөв нь хянагдаад Засгийн газар руу шууд ирдэг. Засгийн газар энийг өөрчлөх эрхгүй шүү энийг байгаа дүнгээр нь төсөвтөө суулга гээд ийм зохицуулалттай ирдэг. Тэгэхдээ яах вэ бид бас Засгийн газар өөрсдийнхөө төсвийн хуулиа бариад бид нарын хувьд бол анхдагч хууль нь бол төсвийн хууль юм аа.

Тийм учраас энэ дүнг авахгүй. Төсвийнхөө боломжийг харж байгаад бид өөрсдийнхөө төлөвлөлтөөрөө боломжтой хэмжээгээр нь багтаана гээд. Ингээд зөрчил үүсээд явдаг юм яваад байдаг. Энэ жилийн хувьд ч юм уу мөн адил бас хөрөнгө оруулалт дээр нь бас ийм асуудлууд үүссэн. Өмнөх хэлэлцүүлгээр бол ингээд Улсын Их Хурал дээр энэ зардал нь суусан, нэмж суусан.

Тийм учраас хэдхэн хоногийн өмнө Улсын Их Хурал дээр дийлэнх Их Хурлын гишүүдийн шийдвэрээр ингээд нэмчихсэн, нэмээд төлөвлөчихсэн, оруулчихсан байгаа энэ зардлуудыг бол бид өөрчлөөгүй тэр хэвээр нь оруулж ирсэн байгаа. Ер нь яг Улсын Их Хурал дээр төсөв нь хянагдаад шууд орох ийм хуулийн заалттай нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн институц нь цорын ганц энд л байгаа юм. Бусад нь бол Төсвийн хуулийн дагуу Засгийн газар дээр төсөв дотор багтаад хянагдаад төлөвлөгдөөд явдаг гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Хариулт болсон уу? Тодруулах уу?

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Байна уу? Байхгүй байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар ТББХ-ноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Болороо гишүүн танилцуулах уу? Болормаа гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг ТББХ явуулж дууслаа.

18.04 цагт

Хоёр дахь асуудалдаа оръё. 2 дахь хэсэг хэлэлцэх асуудал.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхэлье ээ.

Ажлын хэсгийн гишүүд сая өмнөх танилцуулсан ажлын хэсгийн гишүүд байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ ээ.

Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулттай саналтай гишүүн байна уу? Байхгүй байна уу? байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2."Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцье.

"Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Зулпхар гишүүнээр тасаллаа. Би бас асуулт асууна.

С.Зулпхар: Товчхон асуулт ганцхан л асуулт байгаа юм. Монгол Улсын Их Хурлаас 2023 онд Төмөр замын тээврийн тухай хуулийг баталсан. Энэ 10 дугаар зүйл. Энэ мөн хуулийг дагалдан гарсан Их Хурлын тогтоол байгаа. 7 сарын 7-ны өдрийн 72 дугаар тогтоол. Үүгээр Төмөр замын агентлагтай байхаар ингээд тусгагдсан байгаа юм. Тэгээд төмөр зам манай стратегийн ач холбогдолтой салбар л даа. Ер нь захиргааны удирдлага нэгдмэл удирдлагатай байх нь гарцаагүй. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт одоо хүртэл хангагдаагүй явж байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын 2024 оны 7 сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоол Төмөр замын газар агентлаг орхичихсон байгаад байгаа юм. Тэгэхээр одоо энэ хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой асуудлаар бид яах ёстой юм бэ гэдэг л ийм асуултыг би яамныхнаас нь асуумаар байна. Энэ бүтцийг та бүхэн яагаад оруулаагүй юм 1 дүгээрт. Оруулах шаардлагагүй юм уу?

Хоёрдугаарт ер нь одоо бол оруулах боломжтой юм уу? Одоо байгаа төсвийнхөө хүрээнд энийг жишээ нь зохион байгуулах боломж бий юу?

Ц.Сандаг-Очир: Асуултад Сангийн сайд Жавхлан сайд хариулна. Нэг номер хэн бэ? ТНБД Батболд. Нэг номерын микрофон хариул.

С.Батболд: Зулпхар гишүүний асуултад хариулъя. ЗТЯ-ны ТНБД Батболд. 2023 онд Төмөр замын хууль шинэчлэн найруулсан. Энэ дотор Төмөр замын агентлаг байх тухай ийм зохицуулалт орсон. Ингээд Их Хурлын тогтоолоор Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2 агентлаг уг нь байсан боловч сая энэ онд 7 сард энэ төмөр замын агентлагийг хасчихсан байгаа.

Тийм учраас бид нар нэгэнт хууль дээр агентлаг байгаа юм чинь оруулъя гэдэг саналаа тавиад Хууль зүй, Сангийн яамнаас зөвшөөрлөө аваад явж байгаа. Ер нь яагаад агентлаг байгуулах шаардлагатай юм бэ гэхээр 2012 он хүртэл төмөр замын агентлаг байсан тэр өмнө тэр хүртэл бол ер нь манай төмөр зам гэдэг бол УБТЗ-аар л байсан. Өөрөө тээвэрлэдэг, өөрөө дэд бүтэцтэй. Өнөөдөр манай төмөр зам тэр үед 1800 км байсан бол өнөөдөр нийтдээ 4200 орчим километр зам, нийт суурь бүтэц эзэмшигч чин 4 суурь бүтээгч тээвэрлэгч 4. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 250 гаруй аж ахуйн нэгж байгууллага болчихоод байгаа. Тэгэхээр энийг зайлшгүй ийм зохицуулагч ийм байгууллага шаардлагатай байгаа. Манайхаас энэ чиг үүргийг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв гэдэг ийм төсөвт үйлдвэрийн газар одоогоор бол зохион байгуулж байгаа. Ингээд бидний төлөвлөж байгаагаараа л бол Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын

нэгдсэн төвийн төсөв бол манай сайдын багцад байгаа. Энэ дээр яамныхаа тодорхой бас орон тоог энэ агентлаг руу өгөөд ямар нэгэн нэмэлт зардал гарахгүйгээр шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Батболд дарга аа тэр Төмөр замын тээвэр зохицуулалтын газар чинь төрийн үйлчилгээний албан хаагч нар байгаа байх тиймээ. Тэр агентлаг чинь бол төрийн захиргааны албан хаагч болчихно шүү дээ. Яах вэ яамнаас очсон улсууд бол ТЗ байх. Тэгэхээр энийгээ та хэд яаж зохицуулах вэ? Тэнд байгаа улсуудаа бас ажилгүй болгочих нөхцөл байдал үүсэх юм биш үү?

Ц.Сандаг-Очир: Нэг номерын микрофон.

С.Батболд: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жилээс эхлээд бид нар ИНЕГ болон Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд өөрчлөлт орохтой холбоотойгоор хүмүүсээ төрийн албаны шалгалт үндсэндээ өгүүлчихсэн байж байгаа. Бэлдчихсэн байгаа гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Би нэг асуулт асууя.

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай тогтоолоос бид нар анхдугаар хуралдаанаар Засгийн газрын бүтцийг баталчихсан. Гэтэл энэ хавсралтад ХХААХҮЯ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэг агентлаг буюу Ургамал хамгааллын газрыг шинээр байгуулахаар энэндээ нийтдээ 500 орчим тэрбум төгрөгийг төсөвлөөд оруулж ирж байгаа. 500 сая уучлаарай. Тэгээд сая одоо Зулпхар гишүүн яриад байна шүү дээ бас. Яг зарчим адилхан. Бас хуультай. Тэгээд төмөр замын агентлагийг нь байгуулна гэххээд байгуулахгүй. Гэтэл энийг бол бас хуультай хуулийнх нь дагуу байгуулаад ороод ирж байна. Тэгээд ийм 2 ялгаатай асуудлууд байна.

Энэ агентлагийн хэрэгцээ шаардлага нь юу байгаа юм? ХААЯ-ны харьяанд энэ Ургамал хамгааллын газрын. Энэ дээр хэн хариулах вэ? Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя аа. Яах вэ нэг асуудлыг л 2 талаас нь яваад байгаа юм байна л даа. Ургамал хамгааллын газартай энэ нөгөө зун хийгдсэн Засгийн газрын нөгөө хууль нь батлагдчихаад бүтцэд оруулаагүй орхичихсон юм байна лээ. Тэр яг техникийн алдаа гаргасан байна лээ. Тэрнээс хойш ингээд нөхөөд яваад байгаа гэж ойлгож болно.

Харин төмөр замын агентлагийн хувьд бол төсөв орон тоонд нь өөрчлөлт гарахгүй. Тэр нь төсөв талдаа бол тусгагдчихсан. Харин тэр нөгөө Их Хурлаар орох процессоо төсвөөс гадуур зэрэгцээд явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж дууслаа. Саналтай гишүүн байна уу? Зулпхар гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Ер нь яах вэ асуулт нь хариултаа дагуулж байдаг учраас би түрүүн асуусан асуулт маань энэ санал гаргах гэж асуусан юм. Нэгэнтээ бид хуулиа баталчихсан. Хуулийн хэрэгжилтийг хангана гэж байгаа юм. Төрийн захиргааны төв байгууллага агентлаг бол Ургамал хамгааллын газар байгуулагдаж байхад нөгөө

талдаа энэ чинь 250 аж ахуйн нэгж болон Үндэсний хэмжээний стратегийн зорилтыг биелүүлэх чиг үүрэг бүхий агентлаг нь байхгүй байна гэдэг бол өөрөө байж болохгүй зүйл. Би чинь томоохон бүтээн байгуулалт хийх гэж байна шүү дээ. Хийгээд явж байна бас. Тэгэхлээр энэ дээр бол тогтоолын төслийн нэг дэх заалтын Ургамал хамгааллын газар гэсний араас Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газар Хэрэгжүүлэг агентлаг гэсэн хэсэг Төмөр замын газар гэж тусгуулах ийм санал оруулж байна. Гэхдээ бас энэ дээр бас тэмдэглүүлье. Төсөвт бол ямар нэгэн өөрчлөлт орохгүй гэсэн Жавхаа сайд ч гэсэн сая хэлж байна. Төсөв нь байж байгаа. Энэний хүрээнд энийг байгуулаад явах нь зүйтэй гэж үзэж байна аа. Өөрөөр хэлбэл зорилгодоо нийцсэн бүтэц заавал байх ёстой.

Тэгэхээр энийг та бүхэн эрхэм гишүүд маань дэмжиж бас санал хурааж өгөөч гэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж санал чинь хаана байна. Өгсөн юм уу? Зулпхар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулья.

Тогтоолын төслийн нэг дэх заалтын “Ургамал хамгааллын газар” гэсний дараа “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газар Хэрэгжүүлэгч агентлаг хэсэгт “Төмөр замын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гурван гишүүн дэмжиж 23 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Тэгэхдээ тэгээд санал дэмжигдсэнгүй шүү дээ. Тийм санал хураалгаж дууслаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

3.”Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцье.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт асуулттай гишүүн байна уу? Би асууя. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын 2.1 дээр байгаа юм аа. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж үр дүнг тайлагнах гэж. Заавал энэ олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ирж үр дүнг тайлагнах асуудлыг хийнэ гэсэн үг үү? Энийг нэг тодруулж өгөөч.

Хоёрт энэ 3.1.2 дээр нийслэл Улаанбаатар хотоос шилжүүлэн байршуулах боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжид нүүлгэх нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга байгууламжийг худалдах асуудлыг судалж холбогдох арга хэмжээг авахгүй. Энэ бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон. Мөн 2024 оны 01

сарын 01-ээс хэрэгжиж байгаа бас Улсын Их Хурлын бас яг ийм үг өгүүлбэртэй тогтоол байгаа, баталчихсан. Тэгээд ингээд дахин дахин яг энэ агуулгыг ахиад ингээд Их Хурлын тогтоол дээр оруулж ирэх хэрэгцээ шаардлага байгаа нь юу байгаа юм бэ? Яг энэ агуулгаар тогтоол батлагдчихсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бас орчихсон байгаа шүү. Энэн дээр энэ 2 асуулт дээр хариулт өгөөч. Хэн хариулах вэ? Энэ яагаад гараад явчихсан юм бэ? Хурлууд дуусаагүй байхад хэлэлцэх асуудал дуусаагүй байхад.

Учрал сайд байсан. Баасандорж дарга юм уу, Солонгоо дарга дэд дарга нь. Хариулах хүн байна уу? 4 номер Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Сандагаа гишүүний асуултад нэмж хариулъя аа. Яах вэ энэ удаа нөгөө төсөв маань нэлээн тийм таналттай, хэмнэлттэй орж ирж байгаа учраас энийг нэлээн хүчтэй хүч суулгах гээд ингээд Их Хурлаас ийм төсөв дээр алдагдалгүй төсөв батлах хэмнэх зарим үйл ажиллагаанууд дээрээ таналт хийх ийм чиглэл ирээд тэрийг л өшөө их хүчтэй болгож байна л гэсэн үг. Өөрөөр хэлбэл төсөвт орлого оруулах гадна талдаа төрийн ТӨБЗГ-ын хяналтад байдаг энэ үйлдвэрийн газрууд илүү хэмнэлттэй Засгийн газар нь ч ингэж байхад тэр ААН-үүд ч бас яг ийм форматаар явах ёстой гэдгийг илүү үйлчилж байгаа л ийм зүйл. Тэр Улаанбаатар хотоос гаргах сургууль хүрээлэнгүүдийн хувьд ч гэсэн ер нь мөн адил тэрийг л улам л эрчимжүүлэх, ирэх төсвийн жилд ямар нэг тодорхой байдлаар үр дүн гаргаж эхлүүлэх ийм л нэмэлт даалгавар авч байна гэсэн үг.

Тэгээд дахин дахин нэг агуулгаар тогтоол хөтөлбөр эд нар дээр ороод л яваад байгаа шүү. Яг нэг агуулгаар. Учрал сайд тайлбар хийх үү?

Н.Учрал: Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр энэ олон улсын аудит хийлгэх зохицуулалтыг оруулж өгч байгаа. Тэр гол зорилго бол яг өнгөрсөн хугацаанд ашигтай ажиллаж байсан нийтдээ 6 төрийн өмчийн компани дээр олон улсын аудит орж байсан юм байна лээ. Энэ нь юу вэ гэхээр олон улсад IPO гаргах ч юм уу эсвэл үнэлгээ хийлгэхэд мэдээж маш сайн дэмжлэг болдог. Тэр үйл ажиллагааг сайжруулахад л хөндлөнгийн зөвлөмж дүгнэлтүүдийг өгөх ийм зорилготой. Гэтэл алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд дээр мэдээж өөрсдөө зардал гаргаад энэ ажлыг хариуцаад хийхэд бэрхшээлтэй.

Тийм учраас энэ төрийн өмчийн компаниудын засаглалын шинэчлэлийг ярьж байгаа энэ үед он гаргаад хэрвээ Засгийн газраас шийдвэр гаргаад тодорхой компаниуд дээр олон улсын аудит оруулъя гээд шийдэх юм бол мэдээж үйл ажиллагааг нь сайжруулахад маш том дэмжлэг болно. Хөндлөнгийн ийм үнэлгээ хийлгэнэ гэсэн ийм зорилгоор энэ заалтыг оруулсан.

Ц.Сандаг-Очир: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

4.”Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүн байна уу? Асуулттай. Бас нэг асуулт асууя даа бас энэ дээр. Уучлаарай.

Мөн энэ тогтоол дээр авах арга хэмжээний тухай бүх шатны төсвийн байгууллагын тавилга худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх гээд ингээд тэгээд л зөвлөл, хороо, комиссын гишүүнд ажлын хөлс урамшуулал олгох зардлыг 100 хувь бууруулах, 2 дээрээ эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагуудын тээвэр шатахууны зардлыг энэ чинь ингээд өөрөө үндсэндээ Төрийн хэмнэлтийн хуульд бас орчихсон л заалтууд яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр ахиад энэ авах арга хэмжээний талаарх Засгийн газарт чиглэл өгсөн энэ тогтоол дээр оруулах хэрэгцээ шаардлага нь юу байгаа юм бэ? Төрийн хэмнэлтийн хууль дээр бас тодорхой байгаа шүү дээ? Энэ дээр 4 номерын микрофон Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сандагаа гишүүний асуултад яах вэ Төрийн хэмнэлтийн хуульд нэлээн ерөнхий байдлаар орсон байгаа юм. Хэрвээ цаашаагаа одоо ингээд бид алдагдалгүй төсөв батлах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх үр ашиггүй зардлуудаа танахын тулд энийг ингээд маш тодорхой оруулчихсан нь аягүй ойлгомжтой. Цаашдаа тэгэхгүй ингээд тодорхой биш.

Ц.Сандаг-Очир: 4 номерын микрофон.

Б.Жавхлан: Тийм хасаж ингээд танах хэмнэлт хийхэд бол яг гүйцэтгэлийн шатад маш хэцүү. Тийм учраас нэг хуульдаа ингээд маш ойлгомжтой оруулчих юм болчихож байгаа юм. Тэр шатахууны зардал чинь бол яг хэмнэлт хуульд тэгж байдаггүй зөвхөн тээврийн хэрэгслийг нь хязгаарлачихсан байдаг юм. Энд бол тээврийн хэрэгслийг нь хязгаарлаад нэмээд шатахууныг нь хязгаарлаж байгаа хэрэглээг хязгаарлаж байгаа ийм зүйл.

Ц.Сандаг-Очир: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

“2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болормаа гишүүн. Төсөв дээр танилцуулах учраас Болормаагаар яах уу? Улсын Их Хурлын гишүүн Болормаа гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 25 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга захирах хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Гурав дахь хэлэлцэх асуудалдаа орёе.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя аа.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна аа.

Г.Уянгахишиг: Байнгын хорооны танилцуулгыг уншиж сонсгоё.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан ТББХ улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн болно.

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйлд нэмж тусгасан эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүнд баярлалаа.

Улс төрийн намын тухай шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулгатай холбогдуулан асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд Уянгахишиг гишүүн танилцуулна. Байхгүй юм байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүдэд.

18.27 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА